

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.” гэснийг “хуваалт болон татвар, шимтгэлийг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулна” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татвар, шимтгэл, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцно.

2 дугаар зүйл. Тосон-Уул XIX талбайн нөөц ашигласны төлбөртэй холбоотой үүссэн асуудлыг бүтээгдэхүүн хуваах гэрээний 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох хэсэгт багтаан тооцно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг цаашид бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох хэсэгт багтаан нийт газрын тосны 5 хувиар тооцно.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.1.3 дахь заалт нэмсүгэй:

“4.1.3.Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг олон улсын гэрээтэй адилтган холбогдох татварыг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татвар, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.4 дэх хэсэг нэмсүгэй:

“46.4.Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх харилцааг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн нийгмийн даатгалын шимтгэл, актын төлбөрийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт тухай бүр суутган тооцно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг